

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11-12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-13
3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл.....	13-16
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн Захирагч
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.АНХБАЯР ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

᠔᠒᠒3.᠐3.᠒᠒ № ᠐1/᠒77
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Цэцэрлэг сумын орон нутгийн орлогыг 155.7 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 14.1 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 417.1 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Цэцэрлэг сумын Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 25 иргэнтэй холбоотой 75.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна..

Бусад асуудлын хэсэг

Цэцэрлэг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 86.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/ Мянган төгрөгөөр /	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,687,786.4	672,825.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	744,226.9	422,108.9
33	АВЛАГА	163,707.4	115,912.0
34	УРЬДЧИЛГАА	300.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	779,552.1	134,804.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,706,801.8	6,109,150.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	51,725.7	87,900.0
37300	Урт хугацаат зээл	51,725.7	87,900.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,655,076.1	6,021,250.3
39200	Биет хөрөнгө	9,443,977.1	5,373,522.3
39300	Биет бус хөрөнгө	211,099.0	647,728.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,394,588.2	6,781,975.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,871.6	16,799.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,871.6	16,799.9
41300	Өглөг	14,871.6	16,799.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,379,716.6	6,765,175.3
51	Засгийн газрын хувь оролцоо	11,379,716.6	6,765,175.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,950,456.4	1,105,063.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,950,456.4	1,105,063.2
51101	Өмч /төрийн/ /ЛӨҮГ/	3,790,857.0	4,265,341.8
51200	Хуримтлагдсан үр дүн	2,406,577.1	901,300.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,231,826.2	493,469.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,394,588.2	6,781,975.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,204,532.4	1,171,913.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	325,187.2	568,948.5
110	Орлогын албан татвар	136,608.8	366,945.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	136,608.8	387,749.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-20,803.4
113	Хөрөнгийн албан татвар	75,230.0	74,802.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	113,348.3	127,199.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	666,625.0	-454,853.8
120	Нийтлэг татварын бус орлого	666,625.0	-454,853.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,212,720.2	1,057,818.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,493,803.9	1,418,428.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,493,803.9	1,418,428.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,365,721.5	1,370,115.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,337,083.2	403,084.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	306,404.5	51,559.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,326.7	106,437.5
2104	Хангамж, бараа материалын зардал	161,213.8	448,343.0
2105	Нормативт зардал	537,002.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,913.1	50,123.0
2107	Томилолт, зочны зардал	6,007.7	3,441.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,997.8	100,749.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	794,772.6	206,375.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,082.4	48,313.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	710,728.5	-246,515.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	84,548.6	5,392,890.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	626,180.0	-5,639,405.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,630,044.5	1,746,167.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	325,187.2	568,948.5
110	Орлогын албан татвар	136,608.8	366,945.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	136,608.8	387,749.2
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	-20,803.4
113	Хөрөнгийн албан татвар	75,230.0	74,802.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	113,348.3	127,199.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,090.8	7,907.1
1181	Газрын төлбөр	1,657.9	10,360.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	103,599.6	108,932.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,060.2	113,549.4
120	Нийтлэг татварын бус орлого	141,060.2	113,549.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,163,797.1	1,063,669.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,833,582.4	1,848,412.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,833,582.4	1,848,412.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,705,500.0	1,167,169.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,491,113.6	566,819.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	354,753.1	104,400.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,711.2	110,286.9
2104	Хангамж, бараа материалын зардал	278,848.8	182,712.6
2105	Нормативт зардал	230,622.5	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,000.0	50,452.0
2107	Томилот, зочны зардал	6,007.7	3,441.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,529.1	102,008.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,914.0	47,047.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,082.4	681,243.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	796,462.1	-102,244.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	308,051.0	131,973.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	308,051.0	131,973.5
2200	Дотоод эх үүсвэрээр	308,051.0	131,973.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-308,051.0	-131,973.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-87,900.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	87,900.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	488,411.1	-322,118.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	255,815.8	744,226.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	744,226.9	422,108.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,641,481.8	0.0	10,641,481.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36,441.8	0.0	36,441.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,677,923.5	0.0	10,677,923.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-34,708.3	0.0	-34,708.3
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,640.0	0.0	5,640.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	104,681.4	0.0	104,681.4
9	Тайлант үеийн үр дүн	626,180.0	0.0	626,180.0
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,379,716.6	0.0	11,379,716.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,379,716.6	0.0	11,379,716.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-66,112.5	0.0	-66,112.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,313,604.1	0.0	11,313,604.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,542.2	0.0	3,542.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	612,950.0	0.0	612,950.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	474,484.8	0.0	474,484.8
19	Тайлант үеийн үр дүн	-5,639,405.8	0.0	-5,639,405.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,765,175.3	0.0	6,765,175.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,152,746.3	1,993,210.1	159,536.2	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,953,796.3	1,806,360.1	147,436.2	92.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,897.9	1,125,117.1	73,780.8	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,649.7	400,984.9	30,664.8	92.9
210101	Үндсэн цалин	359,830.7	332,776.0	27,054.7	92.5
210102	Нэмэгдэл	45,067.8	44,867.1	200.7	99.6
210104	Урамшуулал	26,751.2	23,341.8	3,409.4	87.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,998.3	51,559.8	4,438.5	92.1
210201	Тэтгэврийн даатгал	38,706.2	35,822.0	2,884.2	92.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,371.7	4,200.5	171.2	96.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,457.0	3,254.9	202.1	94.2
210204	Ажилгүйдлийн даатгал	860.6	751.4	109.2	87.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,602.8	7,531.2	1,071.6	87.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,418.8	459,962.0	10,456.8	97.8
210301	Гэрэл, цахилгаан	25,490.4	21,190.8	4,299.6	83.1
210302	Түлш, халаалт	420,942.6	415,396.8	5,545.8	98.7
210303	Цэвэр, бохир ус	23,985.8	23,374.4	611.4	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	62,016.4	57,039.8	4,976.6	92.0
210401	Бичиг хэрэг	4,650.0	4,065.9	584.1	87.4
210402	Тээвэр, шатахуун	44,500.0	41,243.8	3,256.2	92.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,140.0	2,993.8	146.2	95.3
210404	Ном, хэвлэл	964.0	596.6	367.4	61.9

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	600.0	10.0	590.0	1.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,162.4	8,129.7	32.7	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,019.4	73,140.9	4,878.5	93.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,120.0	26,072.9	47.1	99.8
210604	Урсгал засвар	51,899.4	47,068.0	4,831.4	90.7
2107	Томилолт, зочны зардал	3,500.0	3,441.8	58.2	98.3
210702	Дотоод албан томилолт	3,500.0	3,441.8	58.2	98.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,973.4	44,405.1	4,568.3	90.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,029.7	42,753.9	4,275.8	90.9
210803	Даатгалын үйлчилгээ	70.0	65.5	4.6	93.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500.0	212.0	288.0	42.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	53.0	53.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700.0	700.0	-	100.0
210807	Газрын төлбөр	620.7	620.7	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,321.9	34,582.9	13,739.0	71.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,185.9	25,054.8	11,131.1	69.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,136.0	9,528.1	2,607.9	78.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	754,898.4	681,243.0	73,655.4	90.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	705,525.9	632,929.6	72,596.3	89.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	705,525.9	632,929.6	72,596.3	89.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,372.5	48,313.4	1,059.1	97.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,888.2	38,888.2	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,484.3	9,425.2	1,059.1	89.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,950.0	98,950.0	-	100.0
223001	Бусад хөрөнгө	98,950.0	98,950.0	-	100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	87,900.0	12,100.0	87.9
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.0	87,900.0	12,100.0	87.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,152,746.3	1,688,395.6	464,350.7	78.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	266,752.0	266,752.0	(0.0)	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	266,752.0	266,752.0	(0.0)	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,189,253.4	1,376,568.6	(187,315.2)	115.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,189,253.4	1,376,568.6	(187,315.2)	115.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	696,740.9	45,075.0	651,665.9	6.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.0	41,562.3	58,437.7	41.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000.0	3,512.7	(512.7)	117.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	593,740.9	-	593,740.9	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	450,590.7	(450,590.7)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	145,776.2	(145,776.2)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	78	77	1	98.7
620001	Удирдах ажилтан	11	10	1	90.9
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	55	55	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,495.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,495.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,495.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,100.0
210104	Урамшуулал	2,100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,547.0
210402	Тээвэр, шатахуун	2,532.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,985.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,384.0
210604	Урсгал засвар	3,384.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,464.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,464.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,495.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,495.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,172.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,223.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Цэцэрлэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Цэцэрлэг сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 86.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, могойн бага сургууль, цэцэрлэг гэсэн байгууллагууд нь улсын төсөвт шилжсэн, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, могойн Эмнэлэг нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын 2021 оны 05 сарын 31 өдрийн А/22 тоот захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, ОНХС-ийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэл зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,612.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	744.2	422.1	-322.1
Авлага	163.7	115.9	-47.8
Бараа материал	779.6	134.8	-644.8
Үндсэн хөрөнгө	9,706.8	6,021.3	-3,685.5
Нийт хөрөнгө	11,394.6	6,782.0	-4,612.6
Өр төлбөр	14.9	16.8	1.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,379.7	6,765.2	-4,614.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,394.6	6,782.0	-4,612.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дансны үлдэгдлүүд буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 322.1 сая төгрөгөөр буурсан бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 23161 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 69.6 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэлд 76.2 сая төгрөг, Тэсийн-Илч ХХК-ийн дансанд 31.0 сая төгрөг, Байгаль хамгаалах сангийн дансанд 14.1 сая төгрөг нийт 422.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлагын үлдэгдэлд Тэсийн-Илч ХХК-ийн халаалтын тооцооны 21.2 сая төгрөгийн, НДШ болон татварын 5.5 сая төгрөгийн, ЗДТГ-ын хувь хүнээс авах авлага буюу буруутай шийдвэр гаргаж албан хаагчийг ажлаас чөлөөлсөнтэй холбоотой 13.3 сая төгрөгийн авлага, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн 75.9 сая төгрөгийн авлага нийт 115.9 сая төгрөгийн авлагатай байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 45.1 сая төгрөгийн авлага барагдсан байна. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 25 иргэнтэй холбоотой 75.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, могойн баг сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг гэсэн 7 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 621.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 277.7 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 110.0 сая төгрөг, Соёлын төв 10.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 115.0 сая төгрөг, могойн бага сургууль 53.7 сая төгрөг, могойн цэцэрлэг 42.5 сая төгрөг, могойн эмнэлэг 11.0 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургуулийн 1,396.6 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 1,578.5 сая төгрөг, Соёлын төв 193.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 517.1 сая төгрөг, могойн бага сургууль 328.4 сая төгрөгийн, цэцэрлэг 209.8 сая төгрөгийн, эмнэлэг 106.2 сая төгрөгийн нийт 4,330.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.
5. Өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь байгаль хамгаалах сангийн үлдэгдэл 6.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тэсийн-Илч ХХК-ийн татварын өглөг 4.9 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,171.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,032.6 сая төгрөгөөр буюу 22.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	/сая төгрөг/			
	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	325.2	568.9	243.7	174.9
Татварын бус орлого	666.6	-454.8	1,121.4	-68.2
Тусламж санхүүжилтийн орлого	4,212.7	1,057.8	-3,154.9	25.1
Нийт дүн	5,204.5	1,171.9	-4,032.6	22.5

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь тусламж санхүүжилтийн орлого 3,154.9 сая төгрөгөөр буурахад боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжсэн, Тэсийн-Илч ХХК-ийн 353.5 сая төгрөгийн борлуулалтын орлого, ЗДТГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан 266.8 сая төгрөгийн орлогыг тус тус үр дүнгийн тайлангаас устгал хийж татварын бус орлогыг цэвэр дүнгээр тайлагнасан зэрэг нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,141.7 сая төгрөгийн орлогын давхардсан 27 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,910.3 сая төгрөгийн орлогын давхардсан 25 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 1,148.4 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 3,354.4 сая төгрөгөөр буюу 25.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	/сая төгрөг/			
	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	4,365.7	1,370.1	-2,995.6	31.4
Урсгал шилжүүлэг	128.1	48.3	-79.8	37.7
Үйл ажиллагааны зардлын дүн	4,493.8	1,148.4	-3,345.4	25.6

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Могойн бага сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэсэн 7 байгууллага улсын төсөвт шилжиж тайлант онд орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн зардал 2,198.5 сая төгрөгөөр буюу 25.6 хувиар буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,141.7 сая төгрөгийн давхардсан 27 зарлагын гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,910.3 сая төгрөгийн давхардсан 25 зарлагын гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,212.0 сая төгрөгийн төсөв баталснаас 1,300.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 763.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, урсгал шилжүүлгийн зардалд 48.0 сая төгрөгийг, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 100.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 279.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 936.1 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 415.8 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 100.0 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 467.7 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Цэцэрлэг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 59.2 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 2,152.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 45.1 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 782.8 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 266.8 сая төгрөгийг, эхний үлдэгдлээс 593.7 сая төгрөгийг нийт 1,688.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Цэцэрлэг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 415.9 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 571.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 137.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	5.0	19.0	14.0	380.0
Хөрөнгийн орлого	34.0	37.2	3.2	109.4
Хөрөнгө борлуулсны орлого	10.2	10.1	-0.1	99.0
Шууд бус орлого	3.5	3.9	0.4	111.4
Цалин хөлс шагнал урамшуулал	210.0	317.6	107.6	151.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20.8	-20.8	0.0	100.0
Бууны албан татвар	2.8	2.9	0.1	103.6
Малд ногдуулах албан татвар	65.0	62.0	-3.0	95.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	13.3	9.9	-3.4	74.4
Улсын тэмдэгтийн хураамж	4.8	5.9	1.1	122.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.5	0.1	-1.4	6.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.3	1.9	-3.4	35.8
Газрын төлбөр	5.4	8.4	3.0	155.6
Ойн нөөц ашигласны төлбөр	40.4	37.1	-3.3	91.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	28.6	64.4	35.8	225.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	6.3	5.7	1050.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.1	1.1	-1.0	52.4
Торгуулийн орлого	1.0	2.6	1.6	260.0
Түрээс	3.2	0.0	-3.2	0.0
Дуудлага худалдааны орлого	0.0	2.0	2.0	
ТӨСВИЙН ОРЛОГО	415.9	571.6	155.7	137.4

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Цэцэрлэг сумын орон нутгийн орлого 155.7 сая төгрөгөөр давж биелэхэд Цалин хөлс шагнал урамшууллын орлого 317.6 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 64.4 сая төгрөгөөр биелсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0.1 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлого 3.0 сая төгрөгөөр, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 3.4 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 1.4 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 3.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 3.3 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 1.0 сая төгрөгөөр түрээсийн орлого 3.2 сая төгрөгөөр нийт 18.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 53.4 сая төгрөгөөр төлөвлөж 67.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 14.1 сая төгрөг буюу 26.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	33.7	31.1	2.6	9.2
2	Усны төлбөр	-	0.8	0.8	-
3	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	14.3	28.0	13.7	195.8
4	Зам ашигласны төлбөр	5.5	6.7	1.2	121.8
5	Торгууль	-	0.8	0.8	-
6	Алданги	-	0.04	0.04	-
	Нийт дүн	53.4	67.5	14.1	126.2

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 749.6 сая төгрөгөөр төлөвлөж 1,166.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 417.1 сая төгрөгөөр буюу 55.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	100.4	146.9	46.5	146.3
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	450.0	598.6	148.6	133.0
	Ашигт малтмал /нүүрс/	121.0	222.5	101.5	183.8
3	Агаарын бохирдлын төлбөр	3.9	4.3	0.4	110.2
	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	74.3	194.5	120.2	261.8
	Нийт дүн	749.6	1,166.7	417.1	155.6

Эх сурвалж: Цэцэрлэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого давж биелэхэд Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ын орлого 148.6 сая төгрөгөөр, Ашигт малтмал /нүүрс/-ны орлого 101.5 сая төгрөгөөр, Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/-ны төлбөрийн орлого 120.2 сая төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалсан байна.

Үйл ажиллагааны мөнгөн орлогын талаар

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 2,152.7 сая төгрөгөөр төлөвлөж, 1,688.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 78.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 103.0 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 47.1 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,152.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,953.8 сая төгрөгийг урсгал зардалд, 99.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 100.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,806.4 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 99.0 сая төгрөгийг, эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд 87.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,993.2 сая төгрөг буюу 92.6 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 73.8 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардалд 73.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 60.7 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.4 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 10.5 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 5.0 сая төгрөг
- Эд хогшил урсгал засварын зардал 4.9 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 4.6 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 13.7 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 73.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээнд 705.5 сая төгрөг баталснаас 22 төсөл арга хэмжээнд 632.9 сая төгрөгийг зарцуулж 30.9 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй шалтгаан тендер зарласан боловч гүйцэтгэгч иргэн аж ахуй нэгж материал ирүүлээгүйтэй холбоотой байна. Үүнд: Могойн хүн эмнэлгийн засвар, Могойн бага сургуулийн хүнсний агуулах, нийтийн үйлчилгээний зочид буудлыг дулааны шугам сүлжээнд холбох, хулгана устгалын төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 1,993.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 92.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 3.1 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 4.2 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд худгийн орлого 5.0 сая төгрөг, тэжээлийн үнэ 16.2 сая төгрөг нийт 23.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин нэмэгдэл урамшууллын зардалд 2.1 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардалд 5.5 сая төгрөгийг, урсгал засварын зардалд 3.4 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 12.5 сая төгрөгийг нийт 23.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 51 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 89.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 71.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,418.4 сая төгрөгийг сонгож 22.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Илэрсэн зөрчилд 1.4 сая төгрөгийн 3 төлбөрийн актыг тогтоосон байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 2 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 19.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	19.9	3	19.9	100
Нийт дүн	3	19.9	3	19.9	100

/сая төгрөгөөр/

Өмнөх оны 19.9 сая төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан 1 аж ахуй нэгж нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 94.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитын явцад 246.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 94.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн.

Залруулсан алдааны талаар:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ОНХС-аас шилжүүлсэн 246.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгө, үнэ төлбөргүй гарсан бараа материал дансанд бүртгэж тайлагнасныг үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал дансанд бүртгэж залруулга хийсэн.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчлийн талаар:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 186.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Илэрсэн зөрчилд 1.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 21.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 164.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Үйл ажиллагааны орлогыг 0.6 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 0.1 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлогыг 3.0 сая төгрөгөөр, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 3.4 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 1.4 сая төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 3.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 3.3 сая төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр түрээсийн орлогыг 3.2 сая төгрөгөөр нийт 18.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 25 иргэнтэй холбоотой 75.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 186.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитаар 1.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 21.0 сая төгрөгийн 1 албан шаардлага өгч, 164.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж, акт албан шаардлагуудыг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	1	246.5			1	246.5	1	246.5				
Дүн	1	246.5			1	246.5	1	246.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	2	94.7					3	94.7				
Дүн	2	94.67					3	94.7				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цэцэрлэг сумын ЗДТГ	3	102.0	1	0.7			2	101.3				
Цэцэрлэг сумын ИТХ	1	21.0			1	21.0						
Тэсийн-Илч ХХК	6	63.9	2	0.7			4	63.2				
Дүн	10	186.9	3	1.4	1	21.0	6	164.5				

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО: